



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Г
ДОРНОД АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ СЭРГЭЛЭН
СУМЫН "МОНГОЛ АРДЫН НАМ"-ЫН ХОРООНЫ
ДАРГА Б.ГАНТУЛГА ТАНАА

2024 07. 24 № 526
танай 2024 07. 23 -ны № 09 -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Сэргэлэн сумын 2024 оны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Монгол ардын намын мөрийн хөтөлбөр (гурван хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Сэргэлэн сумын Монгол ардын намд

Хувийг: Дорнод аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт .З... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



Сэргэлэн сумын Монгол Ардын Намын хорооны
2024 оны 07-р сарын 21-ний өдрийн 01 дүгээр тогтоолын
01 хавсралт

**СЭРГЭЛЭН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРООНООС
2024 ОНЫ ОРОН НУТГИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Сэргэлэн сумын Монгол Ардын Намын хороонос 2024 оны Орон нутгийн сонгуульд оролцох Мөрийн хөтөлбөрийг “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Монгол Улсын Их хурлаас баталсан “Алсын хараа*2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, Дорнод аймгийн Монгол Ардын Намаас Орон нутгийн хурлын сонгуульд оролцох Мөрийн хөтөлбөр, Сэргэлэн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах явцад ард иргэдээс гарсан санал, холбогдох байгууллагуудын зөвлөмжийг үндэслэн боловсруулав.

Сэргэлэн сумын Монгол Ардын Намын хороонос 2024 оны Орон нутгийн хурлын сонгуульд оролцох **УРИА: ХӨГЖЛИЙГ ТҮҮЧЭЭЛЬЕ**

Хэрэгжих хугацаа: 2024-2028 он

НЭГ: ТӨР ИРГЭНИЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА


- 1.1. Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 1.2. Төрийн албан хаагч цаг хугацаа, орон зайнаас үл хамааран тасралтгүй сурч хөгжих боломжыг бүрдүүлнэ.
- 1.3. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, амьдралын чанарыг нэмэгдүүлэхэд бодитой анхаарна
- 1.4. Иргэдийн орон нутгийн төсвийн талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, төсвийн ил тод байдлыг хангахад бүхий л талаар анхаарна.
- 1.5. Орон нутгийн төсвийн төлөвлөлтэд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 1.6. Шинэ тутам гарч буй цахим гэмт хэрэгт өртөхөөс ард иргэдээ урьдчилан сэргийлэхэд анхаарч ажиллана.
- 1.7. Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл явцад хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог хангаж, хамтын ажиллагаа бэхжүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

ХОЁР: ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

- 2.1. Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Эрүүл Сэргэлэн хүн” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.2. Хүүхэд багачуудын бие даан ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор гэр цэцэрлэг, хөдөлмөр зуслан, төлчин багачууд, мэргэжил бүхэн сайhan гэх мэт зорилтот ажлуудыг хийж хэрэгжүүлнэ.
- 2.3. Сургалтын үйл ажиллагаанд техник технологийн давуу талыг ашиглах, сургалтын хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулна.

- 2.4. Соёлын биет болон биет бус өв, түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.
- 2.5. Орон нутгийг судлах танхимиын үзмэрийн баяжилтийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ биет болон биет бус соёлын өвийг нээн илрүүлэх, бүртгэлжүүлэх, хамгаалах, олон нийтэд сурталчлах ажлыг хийж хэрэгжүүлнэ.
- 2.6. Соёл урлагийн талаар төрөөс баримтлах бодлого, орон нутгийн соёлын байгууллага, иргэдээс гаргасан санал санаачлагийг дэмжих замаар соёл урлагийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- 2.7. Үндэсний спорт болон бүх нийтийн биеийн тамирын олон талт арга хэмжээг дэмжиж ажиллана.
- 2.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй, таатай орчинг бүрдүүлнэ.
- 2.9. “Аав, эрчүүд”, “Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр”, “Ахмадаа ачлах” хөтөлбөр, “Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөр”, “Хүүхэд эрдэнэ хөтөлбөр” болон хүний хөгжлийг хангахад чиглэсэн бусад төсөл хөтөлбөрүүдийг сум орон нутгийн төвшинд хэрэгжүүлнэ.
- 2.10. Иргэдэд сэтгэл зүйн зөвлөгөө мэдээллийн үйлчилгээг үзүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

ГУРАВ: ЭДИЙН ЗАСАГ



- 3.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд Зүүн бүсийн хөгжилд Сэргэлэн сум нь тодорхой хувь нэмэр бүхий сум байхыг эрмэлзэнэ.
- 3.2. Сэргэлэн сумыг Дорнод аймгийн баруун хойд бүсийн гол зангилаа болгохын төлөө ажиллана.
- 3.3. Мал аж ахуй, газар тариалан, туслах аж ахуйг хослуулан хөгжүүлэх бодлого баримтлана.
- 3.4. Малын гаралтай түүхий эдийг бэлтгэх явцад бүтээгдэхүүний чанарт анхаарч “Дорнод аймгийн Сэргэлэн сумын” гэдэг үнэлэмжийг бий болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ: НОГООН ХӨГЖЛИЙГ ЭРХЭМЛЭНЭ.

- 4.1. Ногоон орчинг бүрдүүлэхэд бүх нийтийн оролцоог нэмэгдүүлж ая тухтай амьдрах боломжийг нэмэгдүүлнэ.
- 4.2. Галын голыг бургасжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 4.3. Галын гол, булаг шанд, нуур цөөрөм, уст цэгийг хамгаалах ажлыг эрчимжүүлнэ.
- 4.4. Байгаль орчны тэнцвэртэй байдал, зэрлэг ан амьтныг хамгаалах ажилд бүх нийтийн хамтын ажиллагааг идэвхжүүлж, нутгийн иргэдийн санал, хяналтад тулгуурлан тарваганы тархац нутгийг нэмэгдүүлэн, сэргээн нутагшуулах ажлыг зохион байгуулна.
- 4.5. Байгаль орчин бохирдуулах гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн хараа хяналтыг сайжруулах, мэдээлэх тогтолцоог бүрдүүлэн, төвлөрсөн хог хаягдлын нэгдсэн цэгийг байнгын арчилгаатай, цэгцтэй байлгана.


- 4.6. Багийн ИНХ-уудаар бэлчээр ашиглах журмыг боловсруулж мөрдлөг болгон ажиллана

ТАВ: БОДИТОЙ БОДЛОГЫН ДЭМЖЛЭГ.

- 5.1. Мал, амьтаны тэжээл, бордооны үйлдвэр, цех байгуулах иргэн, хуулийн этгээдийг бодлогоор дэмжинэ.
- 5.2. Мал нядалгааны цэг, цех байгуулах иргэн, хуулийн этгээдийг бодлогоор дэмжинэ.
- 5.3. Аялал, жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдийг бодлогоор дэмжинэ.
- 5.4. Эрчимжсэн, хагас эрчимжсэн мал, аж ахуй эрхлэх малчин, мал бүхий өрх, хуулийн этгээдийг бодлогоор дэмжинэ.
- 5.5. Туслах аж, ахуй эрхлэх иргэн хуулийн этгээдийг бодлогоор дэмжинэ.
- 5.6. Орон нутагт суурьшин ажиллах хүсэлтэй иргэнийг бодлогоор дэмжинэ.
- 5.7. Өрх бүр жимсний мод тарьж, үр шимиийг хүртэх боломжыг бүрдүүлж, бодлогоор дэмжинэ.

ЗУРГАА: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

- 6.1. Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулна.
- 6.2. Чойбалсан Сэргэлэн сумыг холбосон автозамын ТЭЗҮ боловсруулна.
- 6.3. Төвлөрсөн халаалтын нэгдсэн шугам сүлжээ, уурын зуухны барилгыг ашиглалтад оруулна.
- 6.4. Бага сургуулийн барилгыг / 160 хүүхдийн / бүрэн ашиглалтад оруулна.
- 6.5. Хүүхдийн дотуур байрны барилга шинээр барина.
- 6.6. Төрийн албан хаагчдын 8 айлын орон сууц барина.
- 6.7. Ахуй үйлчилгээний төв байгуулна.
- 6.8. Цэвэр усны станц барина.
- 6.9. Засаг даргын тамгын газрын барилга шинээр барина.
- 6.10. Сэнжит хад"-ыг тохижуулна.
- 6.11. "Мод үржүүлгийн газар нээнэ.
- 6.12. Сэргэлэн суманд цэвэрлэх байгууламж бохирын шугам сүлжээ барих



СЭРГЭЛЭН СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН ХОРОО
2024 он